

МОНГОЛ-ТАЙВАНИЙ ХАРИЛЦААНЫ ТҮҮХ*Ху Жунь Куни**

Монгол-Тайваний харилцаа богино боловч ээдрээтэй замыг туулсан билээ. /Тайвань буюу Дундад иргэн улс/ Нэг талаас түүхэн тодорхой үе Монгол, Тайваний түүхэнд адил төстэй нөхцөл байдлыг үүсгэж байсан бол нөгөө талаас Тайваний дарангуйлах дэглэмийн үед Монголын талаар баримталж байсан үндэслэлгүй, эрс хатуу байр суурь хоёр талын харилцаанд сөргөөр нөлөөлж ирсэн.

1980-аад оны сүүлээр Тайваньд, 1990-ээд оны эхэн үед Монголд өрнөж эхэлсэн ардчилсан үйл явц нь Монгол, Тайваний харилцааг цоо шинэ өнцгөөс харахад хүргэсэн.

Тайвань дахь ардчилсан үйл явц гүнзгийрэхийн хэрээр Монгол улсын тусгаар тогтнолыг бүрэн хүлээн зөвшөөрч, хүндэтгэн харилцах, хоёр талын эдийн засаг соёлын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх зэрэг олон зэрэг үр дагаврууд гарсан.

Өөрөөр хэлбэл, Тайваний улс төрийн шинэтгэл нь Монгол-Тайваний харилцаанд зөргөөр нөлөөлж, шинэ нөхцөлд гаргахад нөлөөлсөн юм.

Монгол-Тайваний харилцааг тоймлон судлахдаа монгол, хятад үндэстнүүд тусгаар тогтнолын төлөө тэмцэж эхэлсэн 1912 оноос эхлэн авч үзэх нь зүйтэй.

Хятад дахь улс төрийн дотоод тогтворгүй байдал удаан хугацаанд үргэлжилсэн, Монгол улсын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөхгүй байсан зэрэг олон шалтгаанаар Монгол-Хятадын харилцаа ээдрээтэй замыг туулсан.

Монгол, Хятадын харилцаанд хамгийн их нөлөөлж байсан хүчин зүйл нь Хаант Орос улс, сүүлд нь ЗХУ-ын Алс Дорнодын талаар баримталж байсан гадаад бодлого байсан гэдгийг судалгааны явцад онцлохыг эрмэлзэв.

Олон улсын харилцааны “Хүйтэн дайн”-ы нөхцөл байдал, Хятадын дотоод иргэний дайн тус улсыг эх газрын коммунист Хятад ба арлын Тайвань гэсэн хоёр хэсэгт хуваасан, Монгол улс социалист эвслийн хүрээнд үзэл сурталжсан гадаад бодлого явуулж байсан, Тайванийг үзэл суртлын тэмцэлдээ ашиглаж байсан АНУ, Монголыг өөрийн үзэл суртлын хүрээнд барьж байсан ЗХУ-ын үл тохиролцоо сөргөлдөөнт байр суурь зэрэг нь Монгол-Тайваний харилцаанд нөлөөлж байсан дотоод, гадаад хүчин зүйлүүд байлаа. Түүхэн явцад Монгол-Хятадын харилцаанд их гүрнүүдийн нөлөө, оролцоо хамгийн их байсныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

* Ху Жунь Куни - Тайвань

1990-ээд оны дунд үеэс Монгол ба Тайвань дахь улс төрийн шинэчлэл, ардчилалд шилжих үйл явц гүнзгийрэхийн хэрээр Монгол-Тайваний харилцаа шинэ нөхцөл байдалд дахин сэргэсэн.

Өнөөдөр хэдийгээр Монгол улс Тайваньтай “Тайвань бол БНХАУ-ын нэг хэсэг” гэсэн албан ёсны байр сууринаас ханддаг боловч энэ нь хоёр талын харилцааг хөгжүүлж болохгүй гэсэн үг биш юм. Өөрөөр хэлбэл, Монгол-Тайваний харилцаа улс төрөөс бусад бүх салбарт дахин сэргэж, ялангуяа соёл, боловсрол, эдийн засгийн салбарт жил ирэх тусам өргөжиж байна.

Монгол-Тайваний харилцааг:

1. 1912 онд хятад үндэстэн тусгаар тогтнох хөдөлгөөн өрнүүлж, Дундад Иргэн улсыг тунхаглаж, улмаар 1949 онд дотоод иргэний дайны үр дүнд нэг үндэстэн эх газрын Хятад ба арлын Тайвань гэсэн хоёр хэсэгт хуваагдах хүртлэх үе (1912-1949)

2. “Хүйтэн дайн”-ы үеийн их гүрнүүдийн нөлөөн доор харилцаа тасарсан үе (1949-1990)

3. Монгол-Тайваний харилцаанд эргэлт гарсан үе (1990 оноос хойшхи) гэсэн түүхэн гурван үед хуваан авч үзэж болох юм.

Нэг намын дарангуйлах дэглэм, их гүрнүүдийн шахалт нөлөөгөөр тасраад байсан Монгол-Тайваний харилцаанд Тайвань дахь ардчилсан үйл явцын нөлөөгөөр шинэ эргэлт гарсныг онцлон тэмдэглэхийг зорьсон болно.

Монгол-Тайваний харилцааны талаарх судалгааны эргэлтэнд түүхэн талыг хамарсан судалгаа бүтээлүүд нэлээд өргөн дэлгэр байдаг бол орчин цагийн Тайваний улс төрийн шинэчлэл, шинэ үеийн Монгол-Тайваний харилцааны талаарх судалгаа хуруу дарам цөөхөн өгүүллүүдээр хязгаарлагдаж байна.

Орчин цагийн Тайваний улс төрийн үйл явц болон Монгол-Тайваний харилцааг ихэнхидээ Зүүн Азийн аюулгүй байдалтай холбон судалсан бүтээлүүд харьцангуй түгээмэл болох нь ажиглагдсан юм.

Монгол-Тайваний харилцааны түүхэн тойм

Монгол, Тайваний харилцааны түүх товч бөгөөд ээдрээтэй замыг туулсан билээ.

Манж Чин улсын ноёрхолд байсан олон улс үндэстнүүд өөрийн тусгаар тогтнолын төлөө үндэсний чөлөөлөх хөдөлгөөн өрнүүлсэн 1910-аад оноос хятад болон монгол үндэстнүүд өөрийн тусгаар тогтнолын төлөө идэвхитэй тэмцэл явуулж байснаараа адил юм. Ийм ч учраас 1911 онд ойролцоо хугацаанд энэ хоёр улсад үндэсний чөлөөлөх хөдөлгөөн ялалт байгуулсан байдаг. Энэ талаар түүхч Л.Жамсран онцлон тэмдэглэж, хятад, монгол ард түмний тусгаар

тогтнолын төлөөх тэмцэл олон талаар адил төст шинжтэй байсан гэж дүгнэжээ. Тэрбээр,

1. Монгол, хятад үндэстний цагаагчин гахай жилийн хувьсгал нь түр боловч тусгаар тогтнож өөрийн төрийг байгуулсны хувьд зорилгоороо нийтлэг байсан.

2. Энэхүү зорилгоо зэвсэгт тэмцлээр хэрэгжүүлэхийг хичээж байсан.

3. Өөрийн тэмцлийг бататгахын тулд гадаад орнуудын засгийн газар, улс төрийн хүчний дэмжлэгийг авахыг эрмэлзэж, хувьсгалаа гаднаас дэмжүүлэхийг зорьж байсан зэргээрээ адил төстэй гэж дүгнэсэн нь оновчтой болжээ.¹ Тэрбээр 2000 онд зохион байгуулсан Монгол-Тайваний хамтарсан хурал дээр тавьсан илтгэлдээ хоёр үндэстний хувьсгалын ялгаатай талуудыг тодорхойлсон нь ихэд сонирхол татаж байгаа юм. Түүний дурдсанчлан Монголын хувьсгалд урьдчилсан тохироо буюу хувьсгалын бүлгэм үүсээгүй, хувьсгалын мөрийн хөтөлбөр боловсруулагдаагүй байсан бол харин Хятадын хувьсгалчдад Сунь Ятсений 18 зүйл мөрийн хөтөлбөр, бүр 1905 онд үүсэн байгуулагдсан “Түнмэнхүй” улс төрийн бүлгэм зэрэг хувьсгал ялахад шаардлагатай улс төрийн нөхцлүүд байсан байна.² Гэвч хувьсгалын үр дүнгийн талаар эрс өөр байр суурьтай байсныг түүний өгүүлээс харж болно. Тухайлбал, Монголчууд Манжийн ноёрхлыг халж, өөрийн хүчээр өөрийн тусгаар тогтносон улсыг түүхэн газар нутаг дээрээ хэрэгжүүлэхийг зорьж байсан бол хятадын хувьсгалчид манжийн төрийг халж, тэдний орыг залган манжийн ноёрхолд байсан олон үндэстнийг газар нутгийнх нь хамт ДИУ-ын бүрэлдэхүүнд оруулахыг зорьж байснаараа чанарын ялгаатай байна. Энэ байр суурь ч хожмоо Монгол-Тайваний харилцаанд сөргөөр нөлөөлсөн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

1911 онд түр ерөнхийлөгчийн албыг хаших болсон Сунь Ятсенийг дэмжигчид 1912 онд Гоминь намыг байгуулж, тайван замаар хувьсгалыг үргэлжлүүлэн засгийн эрхийг бүхэлд нь авахыг оролдсон ч бүтэлгүйтэн, 1913 оноос Гоминьданы үйл ажиллагааг хориглосоноор өрнөдийн загварын жинхэнэ бүгд найрамдах засаглалыг тунхаглан, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тусгаар улс болно гэж зорьж байсан хятадын хувьсгалчид зорилгодоо хүрээгүй.

Харин нөгөө талаас өөрийн тусгаар тогтнолыг тухайн үеийн есөн гүрэнд тунхагласан ч Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд зөвшөөрөхгүй байсаар эцэст нь 1915 оны гурван улсын хэлэлцээрээр Ар Монголыг ДИУ-ын харъяанд автономи эрхтэй байлгахаар тогтсоноор Монголын цагаагчин гахай жилийн хувьсгал үр дүнгээ үзээгүй.³

Эдгээр үндэстнүүдийн 1911 оны хувьсгалын зорилгодоо хүрч тусгаар тогтносон улсаа байгуулж чадаагүй үндсэн шалтгаан нь тухайн

үеийн олон улсын харилцааны нөхцөл байдал байсан. XX зууны эхэн гэхэд дэлхийг колонийн хувьд хуваан захирах их гүрнүүдийн зөрчил дээд цэгтээ хүрэн, их гүрнүүдийн колонийн ашиг сонирхлын шууд огтлолцол нь хуучин Манж Чин улсын газар нутаг болоод байв. Их гүрнүүд колонийн хувьд Манжийн газар нутгуудыг хяналтандаа оруулахаар нэгнээсээ өрсөн тэмцэлдэж байснаас 1911 оны хувьсгалаар Манж Чин улсын төр унасан үйл явцыг өөрийн үндэсний эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэхийг эрмэлзэж байв. Ийм ч учраас тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан монгол, хятад үндэстнүүдийн эрмэлзлийг үл тоон, нэг талаас тунхагласан тусгаар тогтнолыг нь хүлээн зөвшөөрөөгүй төдийгүй, эдгээр нутгууд нь хагас колони байдлаас колони эзэмшил болох таатай нөхцөл бүрдлээ гэж үзэж байсан.

Нэгдмэл төргүй болсон Зүүн хойд Азийн өргөн уудам газар нутагт давуу эрхтэйгээр хяналт тогтоохын төлөө их гүрнүүдийн өрсөлдөөн нь тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх гэсэн дурын оролдлогыг бүтэлгүйтүүлж байв.

1911 онд Хятадын түр засгийн газар болон Богд хааны засгийн газар хоорондоо цаашдын харилцааны талаар ноот бичиг солилцоходоо үндсэндээ Хятадад хэрэг явдал шийдэгдсэний дараа хоёр улс бие биенийхээ тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөлцөх санал тавьсан байдаг.⁴ Гэвч Хятадад улс төрийн хямрал газар авч, улмаар дотоодлоо хоёр хуваагдсан нөхцлөөс шалтгаалан дээрх санал хэрэгжээгүй юм.

Хятад дахь засгийн эрхийн төлөө тэмцэл хурцдаж 1917 он гэхэд Хятад нь Гоминьданы өмнөд Кантоны засгийн газар, Бээжингийн умардын засгийн газар гэсэн хоёр хэсэгт хуваагдсан.

Удалгүй дэгдсэн дэлхийн I дайны дараах АНД-н олон улсын харилцааны асуудлыг зохицуулах 1922 оны Вашингтоны чуулганаар Хятадын асуудлаарх 9 гүрний гэрээ байгуулсан нь угтаа 1901 оны Бээжингийн протоколын шинэ хувилбар буюу Хятадын бүрэн эрхийг хүндэтгэх замаар шинэ колоничлолыг бататгасан хэрэг байв.⁵

XX зууны Монгол-Хятадын харилцааг Орос, сүүлд Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ)-ын оролцоогүйгээр төсөөлөх аргагүй юм. Оросын эзэнт гүрэн, хожим ЗХУ нь Азийн ихээхэн хэсгийг эзлэн оршдог, АНД-д өөрийн шууд ашиг сонирхолтой байсны хувьд Зүүн Азийн нөлөө бүхий улс болох Хятадтай харилцах харилцаанд онцгой ач холбогдол өгсөөр ирсэн. Ийм учраас Оросын Ази руу чиглэсэн гадаад бодлогын чухал чиглэл нь Хятадтай хиллэх хилийн дагуу орших үндэстнүүдтэй харилцах асуудал байсан.

Үүнээс улбаалан энэ үеийн Гадаад Монголын асуудлаар баримталж байсан их гүрнүүдийн байр сууринд Оросын нөлөөлөл хамгийн их байв.

1912 оны Орос-Монголын хэлэлцээрээр Монголын гадаад харилцааг бүхлээр нь Оросын эзэнт гүрэн хяналтандаа оруулж авч чадсан байдаг.⁶ Энэ нь Монгол Оросын нөлөөллийн бүсэд багтсаныг нотолсон хэрэг байв.

Орос нь нэг зэрэг Гадаад Монголын асуудлаас болж олон улсын харилцааны хурцадмал байдал үүсгэхийг хүсэхгүй байснаас 1915 оны Хиагтын гурван улсын хэлэлцээрээр Монголыг Хятадын нэг хэсэг болохыг хүлээн зөвшөөрч, нэг зэрэг өөрийн онцгой ашиг сонирхлыг Хятадаар хүлээн зөвшөөрүүлэн Хятадын засгийн газраар Гадаад Монголын автономн эрхийг хүндэтгэх заалт оруулсан байдаг.

1917 оны Орост өрнөсөн хувьсгалын дүнд засгийн эрхэнд большевикууд гарсан явдал ч энэ улсын Хятад хийгээд, Хятад, Оросын хил дагуу орших жижиг улс үндэстнүүдийн талаар баримтлах гадаад бодлогын чиглэлийг өөрчлөөгүй юм.

1921 онд үндэсний чөлөөлөх хөдөлгөөний эрмэлзэл доор Монголд Ардчилсан засаг тогтсон явдал нь Хятад, Монголын цаашдын харилцаанд нөлөөлсөн. Зөвлөлт Орос нь нэг талаас дотоод иргэний дайнд бүрэн ялалт байгуулах зорилгоор гадна байгаа цагаантны үлдэгдлийг бүрэн цэвэрлэхийг зорихын хамт, большевик засаг төр нь сайн бэхжээгүй байгаа нөхцөлд Азийн хөршүүдтэйгээ харилцаагаа хүйтрүүлэхгүй байхыг эрмэлзэж байсан. Энэ нь Хятад, Оросын дунд орших Гадаад Монголын талаар баримтлах бодлогоор ил харагдаж байв. 1921 оны 11 дүгээр сарын Зөвлөлт Орос-Монголын найрсаг харилцааны тухай гэрээнд Монголын статусын талаар нэг ч үг дурдагдаагүй нь угтаа энэ улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй байх гэсэн Зөвлөлт Оросын ашиг сонирхол байв.⁷ Энэ талаар судлаач Ж.Бор “Зөвлөлт Оросын большевик удирдлага “Монголын асуудлыг” Хятадтай харилцах харилцааны хавсарга болгон үзэж байснаас гэрээ хэлэлцээрийн хэлбэрээр өөртөө том үүрэг хүлээн авахыг аюултайд тооцож байжээ”⁸ гэсэн дүгнэлтийг хийсэн нь оновчтой болжээ.

Өөрөөр хэлбэл, Монгол нь Зөвлөлт Оросын Алс Дорнодын талаар баримтлаж байсан гадаад бодлогын нэгэн чиглэл болох буфер буюу жийргэвч улс болсон байна. 1921 онд Бээжин Ар Монгол дахь большевикуудын үйл ажиллагааг эсэргүүцэж, Ардын засгийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан нь угтаа Гадаад Монгол Хятадын нөлөөнөөс бүрэн гарч, удаан хугацаанд сонирхож ирсэн Оросын нөлөөнд эргэлтгүй орлоо гэсэн болгоомжлолоос үүдэлтэй байв.

Өөрийн хяналтгүй сул газар нутгийг хөрш улстай харилцаагаа сайжруулах бодлогын хүрээнд тогтворжуулан хамгаалах гэсэн Зөвлөлт Оросын санаачлагаар Хятадын засгийн газар-ЗХУ-ын хооронд хэлэлцээ эхлүүлсэн бөгөөд үүний дүнд 1923 онд Хоёр талын харилцааны үндсэн

зарчмын тухай Шанхайн хамтарсан мэдэгдлийг Гоминданы Засгийн газар болон Зөвлөлт Орос улсууд хийсэн юм. Уг мэдэгдлийн хүрээнд Зөвлөлт Орос нь Гадаад Монголыг Хятадын нэг хэсэг болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг.⁹

Удалгүй Бээжингийн засгийн газартай байгуулсан 1924 оны Харилцаа сайжруулах тухай хэлэлцээрээр Гадаад Монгол нь Хятадын нэг бүрэлдэхүүн хэсэг болохыг ЗХУ мөн л хүлээн зөвшөөрсөн.¹⁰

Хэдийгээр ЗХУ нэг талаас Монголын тусгаар тогтнох эрмэлзлийг хүндэтгэн тусалж, өөрийн цэргийг Монголын нутаг дэвсгэр дээр байрлуулж байгаа мэт боловч нөгөөгүүр Хятадын нэг хэсэг мөн гэж далдуур хүлээн зөвшөөрч хэлэлцээр байгуулсан нь Хятад-Зөвлөлтийн ашиг сонирхлын бүс нутгууд болон хил хязгаарыг хамгаалсан таславч бүс буюу жийргэвч үүсгэх замаар аюулгүй байдлаа хангах эрмэлзэлтэй нь шууд холбоотой байв.

Иймээс Монгол улс нь нэг талаас өөрийн тусгаар тогтнолыг тунхагласаар ирсэн боловч түшиж тулж байсан ЗХУ-ын явуулж байсан гадаад бодлогын улмаас хоёрдмол шинжтэй улс төрийн статустай улс болсон юм.

Хаант Оросын, сүүлд Зөвлөлт Оросын явуулсан гадаад бодлогын энэ чиглэл нь Монгол, Түвд зэрэг жижиг улсуудын талаар баримталж байсан Хятадын бодлогыг дэвэргэх гол шалтгаан болж байсан.

Дэлхийн I дайн хийгээд дайны үеийн Японы Зүүн Ази, Хятад дахь цэрэг-дайны идэвхитэй үйл ажиллагаа нь бүс нутгийн улс төрийн нөхцөл байдлыг улам дордуулж, Хятад ба Монгол улсын тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх явц, Хятад-Монголын харилцаанд нөлөөлж байв. Японы Хятад дахь илт түрэмгийлэл БНМАУ-ыг хүлээн зөвшөөрөхгүй боловч, үзэл суртлын аргаар өөрийн нөлөөндөө барьж, аюулгүй байдлаа хангах гэсэн ЗХУ-ын гадаад бодлогыг үргэлжлэхэд нөлөөлсөн.

Ийн 1911-1928 он хүртлэх хугацаанд Хятад болон Монголын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөөгүй.

Хэдийгээр Вашингтоны чуулганаар Хятадын асуудлыг тусгайлан хэлэлцэж, Хятадын асуудлаар баримтлах 9 гүрний гэрээгээр бүрэн эрхийг хүндэтгэнэ гэж заасан боловч угтаа “нээлттэй үүд, хаалга адил тэнцүү боломж” зарчмаар Хятадтай харилцах болно гэснээр хагас колони улс хэвээр үзэж байсныг давхар нотолдог.

1925-1927 онд дэгдсэн Хятадын иргэний дайн хоёр хуваагдаад байсан дотоод улс төрийн бутралыг даван туулж, нэгдсэн засгийн газар байгуулахад чиглэгдэж байсан. Иргэний дайны үед ЗХУ-тай илт дотносож ихээхэн хэмжээний цэрэг-улс төрийн шууд дэмжлэг авч байсан, хятадын улс төрийн гол хүчин Гоминьдан дайнд ялалт байгуулбал, дэлхийн хувьсгалыг түгээх ЗХУ-ын гадаад бодлогын нэгэн амжилт байх болно гэж эмээж байсан өрнөдийн улсуудын

болгоомжлол ч үндэслэлтэй байсныг дурдах хэрэгтэй. Гоминьдан намыг үндэслэгч Сунь Ятсен Зүүн Ази дахь Японы илт түрэмгий санаархлыг таслан зогсоох цорын ганц хүч гэж Зөвлөлт Оросыг үзэж байсны хувьд Оростой харилцаагаа сайжруулах хэрэгтэй гэж үзэж байсан. Мөн Сунь Ятсен большевикуудын туршлага дээр тулгуурлан Хятадыг нэгтгэх боломжтой гэж итгэж байв.¹¹ Иймээс Сунь Ятсений үеэс Гоминьданы нам ЗХУ-тай дотно харилцаж эхэлсэн бөгөөд энэ нь иргэний дайны үеийн Чан Кайшигийн баримтлаж байсан бодлогод ч үргэлжилж байв.

Гэвч Хятад дахь улс төрийн дотоод тэмцэл хурцдахын хэрээр ЗХУ нь Хятадын коммунистуудыг илт шууд дэмжих бодлого баримталж, иргэний дайныг гаднаас дэвэргэгч нэг хүчин зүйл болж байснаас Гоминьданы ЗХУ-ын талаарх байр суурь бүрэн эргэсэн билээ.

Иргэний дайнд ялалт байгуулсан Гоминьдан 1928 оны 7 дугаар сард “Нэгдсэн Хятад улсын Гадаад бодлогын тунхаглал”-даа коммунизм, комминтернийг үл тэвчинэ гэж тодорхой заасан нь өрнөдийн улсуудыг Чан Кайшигийн засгийн газрыг хүлээн зөвшөөрөх гол шалтгаан болсон юм. Иймээс 1928 оны 7-р сард АНУ, 8-р сард Үндэстнүүдийн холбоо, 12-р сард Их Британи Гоминьданы засгийн газрыг хүлээн зөвшөөрч,¹² Хятад олон жилийн дараа сая тусгаар тогтнолоо олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлсэн билээ. Эндээс үзэхэд ЗХУ нь Хятадын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөхөд дам нөлөөлсөн гэж дүгнэж болно.

Үзэл сурталжсан гадаад бодлогыг тунхагласан ЗХУ-ын нөлөөнд автсан гэдэг утгаар БНМАУ-ын тусгаар тогтнолыг өрнөдийн улсууд хүлээн зөвшөөрөхгүй байсан нь дэлхийн II дайныг төгстөл Монгол улс статус-кво орших шалтгаан болж байсан байна.

Монголын асуудлаар баримталж байсан Хятадын засгийн газрын байр суурь 1930 онд Хятадын ГЯЯ-наас илгээсэн доорх мэдэгдлээр тодорхойлогдож байв. “Орос улс Монгол дахь аливаа ашиг сонирхлоос нэгэнт татгалзсан ба шинээр эрэлхийлэх ёсгүй нь илт билээ. Монголын ард түмэн Зөвлөлт хөршийнхөө сүрдүүлэгт автахаас сэрэмжилж, бүхэл улс орны эв нэгдлийн төлөө төв засгийн газрын удирдлагын дор тэмцвээс зохино. Монгол ба Төвдийн харилцааг зохицуулах эрх мэдэл төв засгийн газарт орших бөгөөд энэ талаар нуггийн эрх баригчид гагцхүү гадаад явдлын яамны заалтаар ажиллаж болох юм” гэжээ.¹³ Өөрөөр хэлбэл, олон улсын хэмжээнд тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлсэн 1930-аад оны эхэн үеэс Хятадын засгийн газар Монголыг өөрийн нэг хэсэг гэж үзсэн дээрэнгүй үзлийг гаргаж эхэлсэн байна.

Нөгөө талаас өөрийн тунхагласан гадаад бодлогын чиглэлээс шалтгаалан Хятадын засгийн газрын зүгээс умард хөрш ЗХУ-тай дайсагнасан харилцаанд орсон нөхцөлд “Монголын асуудлыг цэрэг

зэвсгийн хүчээр шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулах нь идэвхжсэн. Энэ нөхцөлд БНМАУ тусгаар улсын ёсоор оршин тогтнохын тулд ЗХУ-ыг түшиглэн түүнтэй тогтоосон харилцаа холбоогоо бэхжүүлэх, тус орны тусламжтай батлан хамгаалах хүчээ зузаатгахаас өөр арга зам байгаагүй”¹⁴ гэсэн дүгнэлтийг түүхч Б.Лхамсүрэн өгсөн нь оновчтой юм.

Өөрөөр хэлбэл, ЗХУ-ын байр суурь, гадаад бодлого нь хятад болон монгол үндэстнүүдийн тусгаар тогтнох эрмэлзэл, явцад нөлөөлсөн гол субъектив хүчин зүйл байсан гэж дүгнэж болох нь.

Дэлхийн II дайны явцад Холбоотон 3 гүрний Ялтын бага хурлын үеэр ЗХУ-ын удирдагч И.Сталин Гадаад Монголын статус-квог хүлээн зөвшөөрөхийг Их Британи, АНУ-ын удирдагчдаас хүсэхэд, АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт Чан Кайшитай ярьж, түүнийг зөвшөөрүүлэх үүргийг өөртөө авсанаар¹⁵ үндсэндээ БНМАУ-ыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх үйл явц эхлэсэн гэж үзэж болно.

Ялтын бага хурлын явцад Гадаад монголын статус-квог их гүрнүүдээр зөвшөөрүүлсэн нь Сталиний монголын ард түмний тусгаар тогтнох эрмэлзлийг хүндэтгэсэн байр суурийн илрэл байгаагүй, ЗХУ-ын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гадаад бодлогын алхам байсан. Үүний үр дүнд “Сталиний хэрэгжүүлсэн Алс дорнод руу чиглэсэн цэрэг стратегийн бодлого нь Монголчууд тусгаар тогтнолоо хамгаалан үлдэж, үндэстэн улс болж чадах сайхан боломж олгосон”¹⁶ гэж түүхч О.Батсайхан зөв үнэлэн дүгнэсэн байна.

Их гүрнүүд Монголын талаар баримтлах бодлогоо өөрчилсөн нь Хятадын хандлага, байр сууринд нөлөөлж, үндсээр нь өөрчилсөн.

1945 оны 7-8 дугаар сард Ялтын хэлэлцээрийн Монголтой холбогдох заалтыг хэрэгжүүлэх асуудлаар өрнөсөн Хятад-Зөвлөлтийн хэлэлцээрийн явцад Монголд төрийн тусгаар тогтнолын асуудлаар бүх ард түмний санал асуулга явуулахыг Хятадын засгийн газар шаардах болсон нь угтаа Ялтын заалтыг тойрч гарах гэсэн оролдлого байсныг тухайн үеийн ЗХУ-ын удирдагч Сталин төдийгүй, Хятадын гол түнш улс болж байсан АНУ-аас Москвад сууж байсан Элчин сайд А.Гарриман нар буруушааж байсныг энд онцлох нь зүйтэй. Тухайлбал, тэрбээр хятадын талын саналыг “Ялтын тохиролцооны нөхцлийг давж гарсан хэрэг”¹⁷ гэж үнэлж байв. Хэлэлцээний дүндхөөр талын засгийн газраас харилцан ноот бичиг солилцон Монгол улсын тусгаар тогтнолыг Японы эсрэг дайн дууссаны дараахийх бүх нийтийн санал асуулгын дүнгээс хамааран хүлээн зөвшөөрөхөөр тохиролцсон.

1945 оны 8 дугаар сард Хятадын үндэсний батлан хамгаалах дээд зөвлөл ба Гоминьданы төвийн гүйцэтгэх хорооны хамтарсан хурал дээр Чан Кайши “Гадаад Монгол нутгийн хүмүүс аль 1922 онд Бээжингийн засаг тогтож байх үед эх улсаас тусгаарласныг тунхагласнаас хойш бараг 25 жил өнгөрчээ. Ийм учраас бид манай хувьсгалт зарчим болон

гоминьданы байнгын бодлогод нийцүүлэн Гадаад Монголын тусгаар тогтнолыг эрс шийдэмгий бөгөөд хуулийн дагуу хүлээн зөвшөөрч найрамдалт харилцаа тогтоох ёстой” гэж хэлж байсан нь угтаа бүх нийтийн санал асуулгын дүнгээс үл хамааран Гоминьдан монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн болохыг нотолж байдаг.¹⁸

Японы эсрэг Алс дорнодын дайнд БНМАУ оролцсон нь “Хятадын дотор нэр хүндээ үлэмж дээшлүүлэхэд”¹⁹ нөлөөлсөн гэж үздэг О.Латтимор зэрэг судлаачдын санал ч үндэслэлтэй юм.

1945 оны 10-р сарын 20-нд БНМАУ-д хятадын ажиглагчдын оролцоотой бүх нийтийн санал асуулга явуулж, сонгуулийн эрх бүхий иргэдийн 98,4% санал хураалтанд оролцсоноос Монгол улсын тусгаар тогтнолын төлөө 100%-ийн санал өгсөн юм.²⁰ 1946 оны 1-р сарын 5-нд Хятадын засгийн газар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл гаргаж, улмаар Монгол улсын засгийн газар Дундад иргэн улсын засгийн газартай 1946 оны 2-р сарын 1-нд харилцан ноот бичиг солилцон дипломат харилцаа тогтоосон.²¹

Уг хэлэлцээний үеэр Монголын талын төлөөлөгчид ДИУ-ын ерөнхийлөгчтэй уулзахад “Хятад, Монгол хоёр улс бол үүний урьд (Манж Чин улсын түрэмгийлэлд ноёрхогдож байсан үед) нэг захиргаанд захирагдаж байсан юм. Японы империализмыг эсэргүүцсэн чөлөөлөх дайны үед хамтран байлдаж байлаа. Одоо БНМАУ нь өрх гэр, өмч хөрөнгөө авч үндэсний бүрэн эрхт тусгаар тогтносон улс болж байна”²² гэж хэлж байжээ.

Гэвч 1949 онд Хятадад өрнөсөн иргэний дайнд ХКН ялалт байгуулж, Гоминьдан тэргүүтэй ДИУ Тайвань арал руу дүрвэн суурьшсанаар хоёр талын харилцаа ахин тасарч, улмаар “хүйтэн дайн”-ы нөлөөгөөр “хүйтэн” харилцаанд шилжсэн.

1949 оны 10-р сарын 1-нд БНХАУ байгуулсныг тунхаглаж, дэлхийн улсуудад дипломат харилцаа тогтоохыг уриалсан тунхагийн хариуд 10-р сарын 6-нд БНМАУ илгээлт явуулж, дипломат харилцаа тогтоохоор тогтсоноо мэдэгдсэн бөгөөд энэ өдөр БНМАУ-аас Москвад суугаа элчин сайд “...Кантоны засгийн газартай дипломат харилцаагаа таслахаар БНМАУ шийдвэрлэснийг”²³ мэдэгдсэн.

Эх газрын Хятадад ХКН засаглал тогтворжихын хэрээр “тогтоон барих” бодлогын хүрээнд АНУ нь коммунизмын аюул заналыг АНД-д түгэн дэлгэрүүлэхгүй байх зорилгоор Зүүн Азийн олон оронтой аюулгүй байдлын гэрээ байгуулж, нэг зэрэг Тайвань дахь Гоминьданы засгийн газрыг идэвхитэй хамгаалж эхэлсэн.

БНХАУ-ыг идэвхитэй дэмжиж байсан Зүүний эвслийн олон орнууд, тэр дундаа Монгол улс Тайваний эсрэг байр сууриа тууштай хадгалж байсан нь хоёр талын харилцаанд нөлөөлж байсан. Эл нөхцөл

байдал нь Монгол-Тайваний харилцаа их гүрнүүдийн ашиг сонирхлын зөрчлийн уршгаар хурцдах гол шалтгаан болсон гэж үзэж болно.

Солонгосын дайнаар АНД-н аюулгүй байдал алдагдаж, ингэснээр АНУ ба ЗХУ, БНХАУ-ын харилцаа хурцалсан. Энэ дайнаас үүдэлтэй хурцадмал байдал намжаагүй байтал 1954 онд эх газрын Хятад Кьюмой, Мацу арлуудыг булаалдан Тайванийг бөмбөгдсөн нь АНУ-ыг цөмийн зэвсэг зөөгч пуужинг Формоза арал дээр байршуулахад хүргэсэн.²⁴ Энэ нь АНУ-ын Тайванийг дэмжсэн бодлогыг идэвхижихэд нөлөөлөв. 1954 оны 12-р сарын 2-нд АНУ Тайваньтай батлан хамгаалахын гэрээнд гарын үсэг зурж, уг гэрээний дагуу 1955 оноос АНУ цэргийн хүчээ Тайваньд байрлуулах болсон нь арлын Тайвань ба эх газрын Хятадын харилцаанд нөлөөлөөд зогсохгүй, хоёр Хятадын засгийн газрын ард байсан тэдгээрийн холбоотнууд хоорондын харилцааг хурцатгаж байв.²⁵

Монголын нэртэй америк судлаач Д.Цолмонгийн үзэж байгаагаар 1954 оны гэрээ нь “Тайванийг АНУ-ын ашиг сонирхлын бүсэд багтааж цаашид хамгаалж байх үүрэг хүлээлгэжээ”.²⁶ АНУ нь Тайванийг шууд ивээлдээ авч шаардлагатай тохиолдолд цөмийн зэвсэг хэрэглэхээр сүрдүүлсэн нь тухайн үеийн олон улсын харилцааг хурцатгах нэгэн шалтгаан болж байлаа.

АНУ-Тайваний харилцаа ба ЗХУ-БНХАУ-ын харилцаа дотносохын хэрээр АНД дахь аюулгүй байдал алдагдаж байв. Учир нь эх газрын Хятад ба арлын Тайваний асуудал нь нэгэнт нэг үндэстний асуудал биш, их гүрнүүдийн ашиг сонирхлын асуудал болж хувирсан юм. Тайвань ба эх газрын Хятадыг тойрсон эл хурцадмал нөхцөл байдал их гүрнүүдийн харилцаанд төдийгүй, Монгол-Тайваний харилцааг ч хурцатгахад нөлөөлж байв.

Тухайлбал, Гоминьданы засгийн газар БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн 1946 оны гэрээнээсээ татгалзаж, тус улсыг НҮБ-д гишүүнчлэн, олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрөх явцад нь байнга саад хийж байв. 1946 оны 6 сараас 1961 оны 10 сар хүртлэх урт хугацаанд БНМАУ нь НҮБ-д элсэхээр нийт 5 удаа өргөдөл гаргаж байсан боловч НҮБ-ын АЗ-д Тайвань байнгын гишүүний суудал эзэлж байсан, социалист БНМАУ нь Тайваний оронд БНХАУ-д АЗ-ийн суудал өгөхийг тал бүрээр дэмжиж байсан зэрэг үзэл сурталжсан нөхцөл байдлаас шалтгаалан Тайваний шахалтаар, Англи, АНУ зэрэг өрнөдийн улсууд санал өгөхөөс удаа дараа түтгэлзэж БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх асуудал хойшлогдсоор ирсэн.²⁷

1960-аад оноос ЗХУ ба БНХАУ-ын хоорондын харилцаа хүйтэрсэн нь Тайваний талаар баримталж байсан АНУ-ын гадаад бодлогод нөлөөлсөн юм.

1971 оны 7 сард Г.Киссенжер Хятадад нууцаар айлчилж, АНУ-ын гадаад бодлогын үйл ажиллагаанд “Ping Pong Diplomacy” хэрэгжиж эхэлсэн.²⁸

1972 оны 2 сард АНУ-ын ерөнхийлөгч БНХАУ-д хийсэн айлчлалынхаа хүрээнд Шанхайн тунхаглалд “Нэг Хятад, хоёр систем” гэсэн зарчмыг гаргаж ирсэн нь Тайванийг Хятадын нэг хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэрэг байсан. Энэ үеэс Хятад-Америкийн харилцаа тогтвортой өргөжсөөр ирсэн бөгөөд ялангуяа, худалдаа эдийн засгийн салбар дахь хамтын ажиллагаа идэвхижсэн.

Нөгөө талаас АНУ нь Тайванийг орхихгүй гэдгээ мэдэгдсээр байсан ч, цэргийн тоогоо цөөрүүлж, удалгүй НҮБ-ын АЗ-ийн байнгын суудлыг БНХАУ-д шилжүүлэхийг дэмжсэн юм.²⁹ 1971 онд НҮБ-ын АЗ-ийн 2758 тогтоол гарч БНХАУ-ын засгийн газрын төлөөлөгчдийг Хятадыг төлөөлөн НҮБ-д суугаа цорын ганц хууль ёсны төлөөлөл гэж хүлээн зөвшөөрсөн юм.³⁰

1979 оны 1 сарын 1-ээс АНУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоож, АНУ 4 сарын дотор Тайваниас цэргээ гаргахаар амласан.³¹

1979 оны 4 сарын 10-нд АНУ-ын Тайваньтай харилцах шинэ хууль гарч, Тайвань дахь ЭСЯ-аа хааж, Засгийн газрын бус статустай байгууллагаар дамжуулан харилцах болсон.³²

Дэлхийн нөлөө бүхий тэргүүлэгч гүрэн АНУ-ын Тайваний талаар баримталсан дээрх бодлого дэлхийн олон улс орны Хятад-Тайваний асуудлаарх улс төрийн байр суурьт нөлөөлсөн. Өнөөдөр нэг ч улс Тайванийг тусгаар тогтносон улс гэж хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд Хятадын нэг хэсэг гэсэн байр сууринаас ханддаг. Монгол улс ч дэлхийн улсуудын нэг адил байр сууринаас Тайваньтай харилцсаар ирсэн.

1980-аад оны эхээр АНУ “Нэг Хятад, хоёр систем”-ийн асуудлаар БНХАУ-тай тохиролцоонд хүрсэн хэдий ч Тайванийг орхиогүй.

“Хүйтэн дайн”-ы дараа ч АНУ-ын ерөнхийлөгч Б.Клинтон Хятад, Тайвань зөрөлдөөнтэй асуудлаа өөрсдөө шийдвэрлэх ёстой гэж мэдэгдэж байсан ч Тайванийг өмгөөлөлдөө барих бодлогоосоо татгалзаагүй юм.³³ Өөрөөр хэлбэл, АНУ нь Тайваний талаар хоёрдмол байр суурьтай бодлогоо халгалсаар ирсэн байна. Жишээ нь, Тайваньд ардчилсан үйл явц идэвхижиж байгаатай холбогдуулан арлын хүн ардын сэтгэхүйд нөлөөлөн сонгуулийн үр дүнд дам байдлаар нөлөөлөхийг оролдсон Шар тэнгис дагуу хийгдсэн хятадын цэргийн сургуулийн хариуд АНУ Номжон далайн 7-р флотоо байлдааны бэлэн байдалд оруулж, Хятадад сануулга өгч байв.³⁴

“Хүйтэн дайн”-ы дараах АНУ-ын Тайваний талаар баримталж байгаа бодлогыг жилээс жилд хүчирхэгжиж байгаа БНХАУ-ын эдийн

засагтай холбодог. “Эдийн засгийн хувьд хүчирхэг БНХАУ нь цаашид эдийн засгийн суурь дээр тулгуурлан цэрэг стратегийн хүрээнд бэхжинэ. Цаашлаад Их Хятад нь... Тайванийг улс төрийн хувьд өөртөө нэгтгэснээр зөвхөн Алс дорнодын манлайлагч гүрэн болоод зогсохгүй дэлхийн тэргүүлэх зэргийн их гүрэн болно”³⁵ гэсэн прогнозийг америкийн геополитикч З.Бжежинский өгсөн байдаг нь ч ортой юм.

Өөрөөр хэлбэл, эдийн засаг-санхүүгийн хувьд хүчирхэг арлын Тайванийг өөртөө нэгтгэснээр БНХАУ нь өөрийн эдийн засгийн чадавхаа өсөн нэмэгдүүлээд зогсохгүй далай тэнгист чөлөөтэй нэвтрэх гарц нь бүрэн чөлөөлөгдөх юм. Нэг үгээр тодорхойлбол, Хятад нь эх газар ба далай тэнгист нэгэн зэрэг хяналт тогтоох чадвартай болно гэсэн үг билээ. Ийм ч учраас АНУ-ын судлаачид болон зарим улс төрчдийн “Хятадын аюул занал”-ын талаарх болгоомжлолыг зарим талаар хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм.

Эл болгоомжлолын хүрээнд АНУ-ын Тайваний талаар баримталж байгаа байр суурь нь өнөөгийн статус-квог урт хугацаанд хадгалах эрмэлзлээр илэрхийлэгдэж байдаг.³⁶ Гэвч Хятадын зүгээс эл болгоомжлолыг үгүйсгэсээр, “хятадын түрэмгийлийн тухай онол” нь өөрийн улс төрийн аюулгүй орчныг хангахад саад хийж байна гэж үзэж байгаа юм.³⁷ Иймээс 2003 оноос “Хятадын энх тайванч сэргэн мандал” гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлэх болсон.³⁸ ЗХА-ын ихэнхи орны эрдэмтэд, тэр дундаа монголын судлаачдын олонхи нь ЗХА-ын аюулгүй байдал ба өөрийн улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нэг хүчин зүйлийг Тайваний хоолойн хоёр эргийн харилцааны асуудал гэж үздэг³⁹ ба Тайваний асуудлыг улс хоорондын гэхээс илүү салан тусгаарлах үзэлтэй холбон тайлбарлах ёстой гэж үздэг.⁴⁰

Иймээс Монгол, Тайваний харилцааны түүхэн тоймыг олон улсын харилцааны түүхтэй уялдуулан авч үзсэн судалгааны дүнд энэ харилцаа илт ярвигтай, байнгын их гүрнүүдийн ашиг сонирхлын шууд нөлөөн дор өрнөж ирснийг тэмдэглэх нь зүйтэй. Өнөөдөр ч их гүрнүүдийн нөлөө байсаар байгааг үгүйсгэхгүй тул Монголын хувьд Тайваний одоогийн статус-квог хадгалахад чиглэсэн болгоомжтой байр суурь нь Монгол улсын үндэсний аюулгүй байдалд ач холбогдолтой юм гэсэн дүгнэлтийг хийж байна.

1990-иэд оны эхэн үе бол Монгол болон Тайваньд ардчилах үйл явц ид өрнөж, Монгол улс олон улсын харилцаанд бие даан нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогоор дамжуулан өөрийгөө илэрхийлж, Тайвань нэг намын дэглэмээс салж, ардчилалд шилжсэн гэдгээ олон улсын тавцанд тунхаглах бодлого баримталж байсан үе юм. Тайваньд ардчилах үйл явц идэвхижихийн хэрээр Тайваний засгийн газрын Монголд хандах хандлага эрс өөрчлөгдсөн. 1987 онд Гоминьданы

дангаараа ноёрхож байсан дэглэм суларсны дараа, мөн 2000 онд баталсан Үндсэн хуулийн шинэглэлээрээ уг хууль эрх зүйн баримтандаа өөрчлөлт оруулж, Монголын талаарх заалтыг хасч, ингэснээр Монгол улсыг тусгаар тогтносон, бүрэн эрхт улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн албан ёсны байр сууриа илэрхийлж эхэлсэн билээ.

2002 онд Тайвань хоёр эргийн иргэд харилцан зорчих асуудлаарх дотоодын хууль тогтоомжоо засварлаж, Хятадын “эх газар” гэдэг тодорхойлолтоос “Гадаад Монгол”-ыг хасч, Монгол улсын иргэдэд гадаадын иргэдийн дагуу виз олгож, Монгол улсын иргэний гадаад паспортыг хүлээн зөвшөөрчээ.⁴¹

Нэг зэрэг холбогдох хууль тогтоомжууддаа засвар өөрчлөлт оруулсны дүнд газрын зурагтаа Монголыг Хятадын эх газраас хасч, цаашид “Гадаад Монгол” хэмээх нэрнээс татгалзан Монгол улс хэмээн нэрлэх шийдвэрийг гаргасан байна.⁴²

1990-2002 он хүртэлх Монгол, Тайваний харилцааг авч үзэхэд хоёр талын нийгэм-улс төрийн амьдралд адил төстэй олон үйл явц ажиглагдаж байв. Үүнд:

1. Аль аль нь ардчилалд тайван замаар шилжсэн. Гэхдээ Тайвань дотоод эдийн засаг-нийгмийн бүтцэнд гарсан өөрчлөлтийн дүнд ардчилалд алгуур аажим шилжсэн бол Монгол олон улсын харилцааны бүтцэд гарсан өөрчлөлтийн үр дүнд богино хугацаанд тайван замаар шилжсэн.

2. Улс төрийн олон намын тогтолцоо бүрэлдэх явцад адил төстэй хандлага гарсан нь хүчтэй хоёр нам сонгуульд өрсөлдөх болсон явдал юм. Монголын улс төрийн амьдралд шинээр хүч төрөн орж ирсэн Ардчилсан нам, далан жил төр барьсан МАХН-ын хүчтэй өрсөлдөгч болж, харин Тайваньд АДН, 40 гаруй жил ноёрхсон Гоминьданы гол өрсөлдөгч болсон. Хэдийгээр олон тооны жижиг намууд сонгуульд өрсөлдөж байсан ч хууль тогтоох байгууллага дахь дийлэнхи олонхи суудлыг эл намууд хуваан авах болсноороо адил байв. Гэвч засаглалын хэлбэр, болон сонгуулийн тогтолцоо ялгаатай. Монгол парламентын бүгд найрамдах улс бөгөөд мажоритар сонгуулийн системтэй бол Тайвань хагас ерөнхийлөгчийн засаглалтай, пропорциональ сонгуулийн системтэй.

3. Ардчилалд шилжих үйл явц гүнзгийрэхийн хэрээр хүн амын улс төрийн идэвхи огцом өссөнөөрөө адил төстэй юм. Энэ нь ялангуяа, сонгуулийн идэвхи, ирцийн дүнгээс харагдаж байсан. Монголд парламентийн сонгууль, Тайваньд ерөнхийлөгчийн сонгуулийн ирц өндөр байдаг.

4. Ардчилал, хүний эрхийн асуудлыг чухалчилахын хэрээр төрөөс ард иргэдийнхээ нийгмийн халамж хамгаалалд илүүтэй анхаарсан бодлогыг явуулж эхэлснээрээ ойролцоо байна.

5. Ардчилалд шилжих явцад өмнөх түүхийн “цагаан толбо”-ыг эргэн сөхөж, тухайн үеийнхээ төрийн бодлогын золиос болж хэлмэгдсэн хүмүүсийн нэр төрийг сэргээж, тэдэнд болон ар гэрт нь нөхөн олговор өгсөн нь ижил байна.

6. Аль алиных нь гадаад бодлогод чухал байр суурийг Хятадтай харилцах харилцаа эзэлдэг. Монгол улсын хоёрхон хөршийн нэг нь Хятад, харин Тайвань бол Хятадтай 1949 оноос хойш Тайваний хоолойн хоёр талын онцгой харилцаатай явж ирсэн.

Хэдийгээр харилцаа холбоо тасарсан байсан ч энэ мэт нийгмийн өөрчлөлтийн адил төстэй байдлууд Монгол, Тайваний хувьд байгаа нь цаашид харьцуулан судлууштай сонирхолтой сэдэв мөн юм.

1992 оны 4-р сарын 30-нд Тайваний ерөнхийлөгч Ли Дэнхуэй нэгэн хэвлэлийн бага хурал дээр Тайвань нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч байгаа гэж зарласан.⁴³ Удалгүй Тайваний санаачлагаар Монгол, Тайваний харилцаа сэргэн, хөгжиж эхэлсэн.

Монгол, Тайваний харилцааг сэргээн хөгжүүлэхэд Монголын талаас Далайн орнууд, бус нутагтай эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх Монголын нийгэмлэг (төрийн бус байгууллага), Тайваний талаас Монгол, Төвдийн хороо (төрийн байгууллага) болон түүний дэргэдэх Дэлхийн Монголчуудын холбоо, Тайваний Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн сан зэрэг байгууллага гол үүрэг гүйцэтгэж ирэв.

Монгол улс дэлхийн олон улсын нэг адил Тайванийг тусгаар тогтносон улс гэж үздэггүй, БНХАУ-ын “нэг улс-хоёр систем”, “энх тайвнаар нэгтгэх” бодлогыг дэмжиж ирсэн. Энэ нь Монгол, БНХАУ-ын харилцааны үндсийг шинэчлэн тодорхойлсон 1994 оны Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээнд мөн тусгалаа олсон байдаг.⁴⁴ Иймд Монгол, Тайваний харилцаа улс төрөөс бусад салбарт хөгжиж эхэлсэн.

2002 оны 9-р сард Тайваний засгийн газар Монгол улсад “Тайбэйн Худалдаа, Эдийн засгийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газар”-аа байгуулсан.⁴⁵

2003 оны 2-р сард Тайбэй хотод Улаанбаатарын худалдаа, эдийн засгийн төлөөлөгчийн газар байгуулагджээ. 2002-2006 оны хооронд Тайваний одоогийн ерөнхийлөгч Чень Шуйбянь Тайбэй хотын дарга байх үедээ, Шинь Жу хотын дарга Цай Рэнь Жиэнь, Тайнань хотын дарга Шу Тиэнь Цай нар айлчилсан.⁴⁶

Сүүлийн 17 жилийн хугацаанд хоёр талын соёл, эдийн засаг, худалдаа, боловсрол, хүмүүнлигийн харилцаа жил ирэх тусам өргөжиж байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Л.Жамсран. Монгол түүх судлалын өгүүллүүд. УБ., 2003.105-р тал
2. Мөн тэнд., 106-107-р тал
3. Ж.Баясах. Хятадын товч түүх. УБ., 2002. 212-р тал
4. Ж.Бор. Монголын дипломат товчоон. УБ.,1998. 225-р тал
5. Н.Е.Клеймонова и др.Версальско-Вашингтонская система МО: проблемы становления и развития. М.,1995. сс.96-97
6. Ж.Бор. Монголын дипломат товчоон. УБ.,1998. 225-р тал
7. А.Ю.Сидоров. Внешняя политика Советской России на Дальнем Востоке. М.1997, с.65
8. Ж.Бор. Монголын дипломат товчоон. УБ., 1998. 255-р тал
9. Н.Е.Клеймонова и др.Веральско-Вашингтонская система МО: проблемы становления и развития. М., 1995. с.106
10. Мөн тэнд., с.107
11. А.Ю.Сидоров. Внешняя политика Советской России на Дальнем Востоке. М., 1997. с.115
12. Н.Е.Клеймонова и др.Веральско-Вашингтонская система МО: проблемы становления и развития. М., 1995., с.115
13. Friters.G.M. Outer Mongolia and its International Position. Baltimore. 1949., p.200
14. Б.Лхамсүрэн. Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол. УБ., 1995. 60-р тал
15. Ц.Батбаяр. ХХ зууны эхэн хагасын Монгол, Японы харилцаа. УБ., 1998. 174-р тал
16. О.Батсайхан. Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд(1911-1946). УБ., 2005. 328-р тал
17. “Дундад, Зөвлөлтийн найрамдал, холбооны тухай 1945 оны гэрээний талаар хийсэн хэлэлцээний далд учир”. Л.Жамсрангийн орчуулга. “Дорно дахины судлалын асуудал” 1989. №2, 21-р тал
18. Friters.G.M. Outer Mongolia and its International position. Baltimore., 1949. p.211
19. Western Political Quarterly. March. 1956.p.41
20. Ж.Бор. Монголын дипломат товчоон. УБ.,1998. 292-р тал
21. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхэтгэл. I боть. 280-р тал
22. С.Рэнцэнсоном. “БНМАУ, ДИУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосон тухай бяцхан дурсамж” //”Ертөнцийн чихнээ. Монгол элч нарын дурсамж”. УБ., 1991. 93-р тал
23. Б.Лхамсүрэн. Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол. УБ. 1995, 95-р тал

24. Д.Цолмон. АНУ-ын гадаад бодлогын түүх, дипломат ажиллагаа. УБ., 2005. 219-р тал
25. Д.Наран. Хятадын түүх.УБ., 2002.155-р тал
26. Д.Цолмон. АНУ-ын гадаад бодлогын түүх, дипломат ажиллагаа. УБ. 2005., 219-р тал
27. Д.Цэвэгмид. “Бартаатай замыг давав” //”Ертөнцийн чихнээ. Монгол элч нарын дурсамж” УБ., 1991. 77-83-р тал
28. Д.Цолмон. АНУ-ын гадаад бодлогын түүх, дипломат ажиллагаа. УБ., 2005. 250-р тал
29. Мөн тэнд.,
30. “UN Membership and Regional security”. //”Taiwan Review” September 2006., р.1
31. Д.Наран. Хятадын түүх.УБ.2002.213-р тал
32. “The Quiet Americans”. //”Taiwan Review” November 2003. pp.25-26
33. Д.Цолмон. АНУ-ын гадаад бодлогын түүх, дипломат ажиллагаа. УБ., 2005. 288-р тал
34. Мөн тэнд.,
35. З.Бзежинский. Великая шахматная доска. М.1999.с.190
36. Д.Цолмон. ЗХА-ийн бүс нутаг дахь АНУ-ын гадаад бодлогын стратеги, түүний хувьсал өөрчлөлт.. //”ЗХА-ийн төлөв байдал ба Монгол улс” УБ., 2003.90-р тал
37. Н.Ариунгуа. БНХАУ-ын гадаад бодлогын үндсэн чиглэл. Хятад ба их гүрнүүдийн харилцаа. //”БНХАУ-ын өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого” УБ., 1999. 126-р тал
38. Ц.Батбаяр.Хятадын “энх тайванч сэргэн мандлын” үзэл баримтлал”. //”Өнөөгийн Хятад” 2005, №1.,22-р тал
39. А.Түвшинтөгс. ЗХА-д аюулгүй байдлын олон талт механизм бүрэлдэх боломж ба Монгол улс. //”Олон улсын харилцаа”, 2004 №2.,20-р тал
40. А.Түвшинтөгс. АНД-н бүс нутгийн аюулгүй байдлын тойм. //”Стратеги судлал”, 2005 №3., 62-р тал
41. М.Батчимэг. Тайвань Монголыг сонирхож байна.//”Стратеги судлал” 2002 №2-3, 120–р тал
42. Мөн тэнд.,
43. Д.Золбоо. Монгол-Тайваний соёл, эдийн засгийн хамтын ажиллагаа. //”Олон улс судлал” 2005 №4, 77-р тал
44. Н.Алтанцэцэг. Монгол улс, БНХАУ-ын харилцаа. //”БНХАУ-ын өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого” УБ., 1999. 146-р тал
45. “ДИУ-ын (Тайвань) үндэсний баярт зориулсан тусгай хэвлэл”. УБ., 2006.1-р тал
46. Мөн тэнд., 5-6-р тал